



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/300

Номгон

“Автомашин, тээврийн хэрэгсэлгүй
өдөр болгох тухай

“Би биш бид” аяны хүрээнд Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сар хүртэлх хугацаанд сар бүрийн эхний 7 хоногийн Бямба гаригийг “Автомашин болон тээврийн хэрэгсэлгүй өдөр” болгон зарласугай.


2. “Автомашин болон тээврийн хэрэгсэлгүй өдөр”-үүдэд аймаг, сумын төв зам болон төв замруу орсон чиглэлүүдэд өглөөний 09⁰⁰ цагаас оройны 18⁰⁰ цаг хүртэл зорчих автомашин тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.

3. Орон нутгийн замын нөхцөл байдалд тулгуурлан хөдөлгөөний хязгаарлалтыг тогтоохыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Автомашин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласан хугацаанд хамгаалалтын болон нэмэлт тэмдэг, тэмдэглэгээг төв замд байрлуулах, иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулан, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийг иргэд аж ахуйн нэгж, төрийн байгууллагад шуурхай мэдээлж уг өдрүүдээр автомашины хэрэглээг багасгах, өөр төрлийн зорчих хэрэгслийг сонгох зөв дадлыг иргэд, олон нийтэд уриалсан мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээллийн албанд даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

521010767

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx